





2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх” гэж, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтад “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй” гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхийн эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал өндөр байгаа энэ цаг үед манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 6 сард дунджаар 70 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 40 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 6 сард 6.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 20 хувь буюу 1.3 тэрбум ам.доллараар, төсвийн нийт орлого 14.0 их наяд төгрөг болж, 6 хувь буюу 0.9 их наяд төгрөгөөр тус тус буураад байна. Цаашдын дэлхий дахины эдийн засаг дахь тодорхой бус байдал үргэлжлэх эрсдэл өндөр байгаагийн улмаас манай улсын эдийн засгийн нийт эрэлт саарах хандлага үргэлжлэх төлөвтэй байна.

Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг 33.4 их наяд төгрөг байхаар баталсан.

Эдийн засгийн дээрх нөхцөл байдлын улмаас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дүн хангагдахгүй байх эрсдэл үүсээд байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдөр “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй” байхаар нэмэлтээр тусган баталсан.

Дээр дурдсан нөхцөл байдал болон хууль, эрх зүйн орчинтой уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл дэх макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах төсвийн бодлогыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль, тогтоомжийн төсөл байхгүй болно.